



"БАГА АНГИЙН БАГШ"-ИЙГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН УДИРДАМЖ

Зорилго: Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны А/07 дугаартай тушаалаар батлагдсан "Чадварлаг багш" арга хэмжээ, бага ангийн багш нарын хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлэх, нийгмийн хамгааллыг дэмжих, боловсролын олон талт үйл ажиллагаанд бага ангийн багш нарыг хамруулах, багшлахуйн ур чадвар, санал, санаачилгыг дэмжин урамшуулах, хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих шилдэг арга зүй, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хэрэгжих хугацаа: 2025 оны 02 дүгээр 14-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Хамрах хүрээ: Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын багш нар

Шагналын сан: Багш тус бүрт 20.0 сая төгрөг, нийт 560.0 сая төгрөг

Санхүүжилтийн эх үүсвэр: Орон нутгийн төсөв

Оролцогч багш нарт тавих нийтлэг шаардлага:

1. Мэргэжлээрээ тогтвор суурьшилтай 3-аас дээш жил ажилласан байх
2. Багш мэргэжлийн ёс зүйг чанд сахин баримталдаг байх
3. Багш мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг өндөрт өргөдөг байх
4. Хүүхдийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэх чиглэлээр санал, санаачилгатай ажилладаг байх
5. Нийгмийн сайн сайханд хувь нэмрээ оруулах эрмэлзэлтэй байх
6. Сургалтад мэдээлэл, харилцааны технологийг бүтээлчээр ашиглах чадвартай байх
7. Сургууль, хамт олон, сурагч, эцэг эх, олон нийтэд ажил, амжилтаараа танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн байх
8. Шавь нар нь сурлага, урлаг, хүмүүжил, спортын амжилт бүтээл гаргасан байх
9. Хүүхдийн хүмүүжил, хөгжил, төлөвшилд эцэг эх, асран хамгаалагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэх, эцэг эх, асран хамгаалагч нэг бүртэй ажилладаг туршлагатай байх
10. Боловсрол судлал, хүүхдийн сэтгэл зүй, хүүхэд хамгаалал, тэгш хамруулах боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролын талаар сургалт зохион байгуулахад хамтран оролцсон туршлагатай байх

Оролцогчдыг бүртгэх: Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багшаар ажиллаж буй "Нийтлэг шаардлага"-ыг хангасан багш бүр оролцох эрхтэй бөгөөд 2025 оны 02 дугаар сарын 14-20-ны хооронд бүртгэнэ.

Бүртгүүлэхдээ танилцуулга, цаашдын зорилго бүхий бичлэгийг 2-3 минутад багтаан, Youtube-д байршуулсан линкийг хуулж, бүртгүүлнэ.

Танилцуулгын бүтэц:

1. Танилцуулгын эхний хэсэгт ажил мэргэжилдээ оруулсан хувь нэмэр, хичээл сургалтын үйл ажиллагаанд оруулсан шинэлэг санаа, ахиц өөрчлөлт, ур чадвар, заах арга барил, зайн сургалт зохион байгуулалтын талаар дурдсан байна.